



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/205

Булган сум

Шууд худалдан авах  
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Татварын хэлтсийн тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгч “Вилла проект” ХХК-тай 14 940 000 (Арван дөрвөн сая есөн зуун дөчин мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Татварын хэлтэс (Д.Лхагвасүрэн)-т олгосугай.

2.Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Татварын хэлтэс (Д.Лхагвасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Вилла проект” ХХК-ийн захирал (Ч.Сод-Эрдэнэ)-д даалгасугай.

4.Тус барааг хууль, журам, гэрээний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

5.Шууд худалдан авах эрх олгох тухай 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/168 дугаар захирамжийг уг захирамжаар хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010171